



**БУЛГАН АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 он



АГУУЛГА

НЭГ. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр

- 1.1. Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн талаар..... 1
- 1.2. Хяналт шалгалтын чиглэлээр 1-2
- 1.3. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2-3
- 1.4. Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын
бүртгэлийн чиглэлээр 4-5
- 1.5. Санхүүгийн чиглэлээр 5-7
- 1.6. Архивын үйл ажиллагааны чиглэлээр 7-8
- 1.7. Мэдээлэл технологийн чиглэлээр 8-10

ХОЁР. Сургалт семинар зохион байгуулсан болон хамрагдсан

байдлын талаар..... 10-15

ГУРАВ. Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг

хангах чиглэлээр 15-21

ДӨРӨВ. Идэвх санаачилга, шинэлэг ажлын талаар 22-29

ТАВ. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 30

ЗУРГАА. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд...31

ДОЛОО. Бусад ажлын хүрээнд32-34



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн талаар:

Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулан бүртгэлийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар 30 албан хаагчтайгаар иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр Булган аймгийн 1 тосгон 16 сумын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Тус хэлтэст 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар нийт ирсэн албан бичиг 810, үүнээс хариутай 726 албан бичгийн 713 албан бичгийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Хугацаа болоогүй 13 албан бичиг байгаа бөгөөд явуулсан албан бичиг 713, өргөдөл гомдол нийт 42 ирснээс хуулийн хугацаанд нь 41 өргөдлийг шийдвэрлэж хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. 1 өргөдлийн хуулийн хугацаа болоогүй шалгагдаж байна. Мөн хэлтсийн даргын А тушаал 19, Б тушаал 5 гарсан бөгөөд тушаалын хэрэгжилтэд хэлтсийн дарга болон тушаалтай холбоотой албан хаагч тус бүр тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хэлтсийн үнэт цаасны зарцуулалт, бараа материалыг тоо бүртгэлээр хөтөлж сар бүрийн 5-ны өдрийн дотор албан хаагчдын үнэт цаасны тайланг нэгтгэж УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст ts.ganchimeg@burtgel.gov.mn хаягаар тогтмол хүргүүлж хэвшсэн.

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар УБЕГ-аас тус хэлтэст холбогдуулан ирүүлсэн 24 тушаал байгаагаас А тушаал 14, Б тушаал 10 ирсэн байна.

2025.03.18-ны өдрөөс Ц.Хуланг Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр, 2025.05.07-ны өдрөөс Г.Солонго Тэшиг сумын улсын бүртгэгчээр, 2025.10.01-ний өдрөөс Ц.Цолмонтайяаг Хялганат тосгоны улсын бүртгэгчээр тус тус томилж, Рашаант сумын улсын бүртгэгчийн сул орон тоог нөхөх шалгалтыг журмын дагуу зарлуулж хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчид холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна.

1.2. Хяналт шалгалтын чиглэлээр:

Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны улсын бүртгэл хөтлөх болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор 4 удаагийн урьдчилсан хяналт шалгалт, 1 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг удирдамжийн дагуу гүйцэтгэж шалгалтын үр дүнд илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж ажилласан.

✓ Тайлант хугацаанд бүртгэлтэй холбогдуулан ирүүлсэн 54 өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд архивын эх нотлох баримттай тулган шалгаж хяналтын улсын байцаагчийн 71 дүгнэлт гарган шийдвэрлэсэн.

Дүгнэлтийг авч үзвэл:

Иргэний бүртгэлийн чиглэлээр - 27

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр – 5

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр - 39



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

✓ Хяналт шалгалтын зөрчлийн нэгдсэн санд бүртгэлтэй шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй 29 хэрэг маргааны бүртгэлд хяналт тавьж 29 хэрэг маргааныг шийдвэрлэж баталгаажуулсан болно.

✓ Захиргааны зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар өнөөдрийн байдлаар 201 иргэн, 2 хуулийн этгээдийн зөрчлийг шалган шийдвэрлэж 5,200,000 /дөрвөн сая хоёр зуун хорин мянга/ төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан.

✓ Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 байгууллагын албан хаагчдад мэдээлэл сургалт орж, Булган аймгийн Хялганат тосгонд “Зөвлөө, бүртгэе” арга хэмжээг зохион байгуулан иргэд олон нийтэд сургалт мэдээллийг хүргэж ажилласан.

✓ Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 1 дүгээр улирлын байдлаар зөрчил шалган шийдвэрлэсэн нийт зөрчлийн хэрэг материалыг Булган аймгийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Ц.Сувдаад бүрэн хянуулж, бүртгэлийн дэвтэрт хянасан тухай тэмдэглэл үйлдүүлэн холбогдох арга хэмжээг авч, “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг бий болгох ажлын хүрээнд хийгдэж буй урьдчилан бэлтгэл хангах ажлын хүрээнд Булган аймгийн Шалган шийдвэрлэх байгууллагын Хамтарсан зөвлөгөөн зохион байгуулагдаж уг арга хэмжээнд хамтран оролцлоо.

1.3. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2025 оны эхний хагас жилийн байдлаар ИУБГ-аас зохион байгуулсан 1 удаагийн цахим сургалт, 1 удаагийн танхимын сургалтад бүрэн хамрагдсан. ИУБТ-аас 2025 оны эхний хагас жилийн байдлаар улсын бүртгэгч нарт 2 удаагийн чиглэл боловсруулан хүргүүлж, 6 удаагийн цахим сургалтыг зохион байгуулан улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2025.11.10-ны өдрийн байдлаар иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 8040 бүртгэл хөтөлж хуулийн хугацаанд баталгаажууллаа. Үүнд:

- ✓ Төрөлт 550
- ✓ Үрчлэлт 18
- ✓ Овог, нэр өөрчилсний бүртгэл 39
- ✓ Эцэг/эх/ тогтоосны 33
- ✓ Гэрлэлтийн бүртгэл 121
- ✓ Гэрлэлт цуцлалт 35
- ✓ Нас баралт 331
- ✓ Шилжилт хөдөлгөөн 818
- ✓ Иргэний үнэмлэхийн бүртгэл 2092
- ✓ Гадаад паспортын бүртгэл 1310
- ✓ Нэмэлт өөрчлөлт 2693 бүртгэл тус тус бүртгэгдсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр эхний хагас жилийн байдлаар нийт 6632 лавлагаа олгосон байна. Үүнд:

- Хууль, хяналтын байгууллагад 395 лавлагаа
- Иргэнд 4740 лавлагаа
- Албан хэрэгцээнд 1259 лавлагаа мэдээллийг тус тус олгож, мэдээллийн санд үүсгэсэн байна.

Мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд:

Нэгдсэн архивын газраас “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх” тухай 2025.04.09-ний өдрийн 9/4940 тоот албан бичгийн хүрээнд иргэний улсын



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

бүртгэлийн мэдээллийн санд төрөлтийн 30 бүртгэл, нас барсны 30 бүртгэл, гэрлэсний 50 бүртгэл нийт 110 бүртгэлийн хөрвүүлэлтийн алдааг архивын эх нотлох баримтыг үндэслэн засч мэдээг нэгдсэн архивын газарт хүргүүлж ажиллалаа. Улсын бүртгэгч нарын 2024-2025 онд бүртгэсэн иргэний үнэмлэхийн бүртгэлд хяналт тавьж өмнөх иргэний үнэмлэхийг хүчингүй болгосон эсэх, иргэний үнэмлэх олголтын бүртгэл хийсэн эсэхийг шалгаж өмнөх иргэний үнэмлэх хүчингүй болгоогүй 700 гаруй иргэний үнэмлэхийг хүчингүй болгож ажиллалаа

Тоон гарын үсэг олголтын талаар:

Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын зөөврийн төхөөрөмжийг ашиглан 2025.02.04-ний өдөр ХААИС-ийн харьяа Политехникийн коллежийн 12 оюутан, 2025.03.14-ны өдөр “Булган Мээж” ХХК-ны 7 албан хаагч, 2025.06.06-ны өдөр Хялганат тосгоны 19 иргэнд, 2025.06.24-ний өдөр Хутаг-Өндөр сумын 22 иргэнд, 2025.10.17-ны өдөр Орхон сумын 16 гаруй иргэнд тус тус тоон гарын үсэг олголоо. 2025.11.10-ны өдрийн байдлаар нийт **23773** иргэнд тоон гарын үсэг олгож зорилтот түвшинд хүрлээ.



Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн 10 сумын 10 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах чиглэлийн хүрээнд СНЖ-ын хэсгийн дугаарыг 2024 оны ээлжит сонгуулийн хэсгийн дугаар, сумын ИТХ-ын тогтоолтой тулган нягтлан шалгахад хэсгийн дугаар зөв үүссэн байна. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй сонгогчийн тоог 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчийн тоо болон тайлангийн програмын хүн амын тоотой харьцуулан шалгалаа.

Сонгогчийн нэрийн жагсаалтад нийт 6077 сонгогч бүртгэлтэй байгаа бөгөөд хэсэгт бүрэн оноогдсон байна. 2025.01.01-2025.03.20-ны хооронд нас барсны бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг шалгахад сонгогчдын нэрийн жагсаалтаас хасагдсан байна. 2024.10.11-2025.03.20-ны хооронд шилжин ирсэн 121 иргэний мэдээллийг шалгахад 35 иргэн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлгүй байсан ба санал авах байранд хаяг нэмснээр сонгогчдын нэрийн жагсаалтанд нэмэгдэж бүртгэгдсэн. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлгүй, хэсэг буруу оноосон зөрчил байхгүй байна.

Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24-р зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2025.04.21-ний



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

өдрийн А/71-р тушаал болон 2025.04.16-ны өдрийн 2/5282 тоот албан бичгээр ирсэн зөвлөмжийг албан хаагчдад танилцуулан зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуулийн хугацаанд баталгаажуулж дууссан. Сонгуулийн санал авах өдөр алдаа зөрчилгүй ажилласан.

1.4. Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2025.11.10-ны өдрийн байдлаар тасгийн дарга, эд хөрөнгийн 2 улсын бүртгэгч, хуулийн этгээдийн 1 улсын бүртгэгч, суманд эрхзүйч мэргэжилтэй эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл хийх эрх авсан 8 сумын улсын бүртгэгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэлтсийн даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу улсын бүртгэгч Б.Одончимэгт Баян-Агт, Бүрэгхангай, Орхон, Дашинчилэн, Хялганат, Рашаант, Могод, Булган сумын 1,3,5 дугаар баг, улсын бүртгэгч Н.Билгүүнд Баяннуур, Бугат, Гурванбулаг, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Сайхан, Булган сумын 2,4,6 дугаар багийг хариуцуулж бүртгэл хийлгэж байна. Эд хөрөнгийн нийт 4217 бүртгэл бүртгэгдсэнээс газрын 1907 бүртгэл, үл хөдлөхийн 2310 бүртгэл хийгдсэн байна. Үйлчилгээний хураамж 63,305,891 төг, Тэмдэгтийн хураамжийн орлого 4,237,962 төг, татварын орлого 260,247,100 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Эд хөрөнгийн лавлагааг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар нийт 190 лавлагааг иргэн, хуулийн этгээдэд мэдүүлгээр олгосон байна. Үүнээс улсын бүртгэгч Н.Билгүүн-76 лавлагаа, Б.Одончимэг-84, сумын улсын бүртгэгч нар 30 лавлагааг олгосон байна. Улсын бүртгэгч Н.Билгүүний зүгээс хуулийн хяналтын байгууллагын 27 лавлагааг гаргасан бөгөөд хугацаатай албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлэн ажилласан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон үзүүлэлт:

Үзүүлэлт		Үйлчилгээний тоо
1. Нийт бүртгэлийн тоо		4217
2. Анхны бүртгэлийн тоо		740
Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл	330	225
	-	-
Газар өмчлөх эрхийн улсын бүртгэл		
	410	164
3. Гэрээний эрхийн бүртгэлийн тоо		927
Өмчлөх эрх шилжүүлэх гэрээ, хэлцэл	648	305
	102	62
	3	-
	104	43
	2	2
	10	8
	57	26
	-	-
Барьцааны гэрээ, барьцааны эрх дуусгавар болгох бүртгэл	1	-
	1412	681
	923	491
Бусад гэрээ	6	3



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

4. Бусад бүртгэлий тоо		125
Бусад бүртгэл	182	110
	5	2
	5	3
	18	10

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар:

Хуулийн этгээдийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-н ы өдрөөс эхлэн Улсын бүртгэгч Н.Билгүүн бүртгэлийг хийж 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Б/117 дугаартай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар Ц.Хулан хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр томилогдон өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Хуулийн этгээдийн бүртгэгч Ц.Хулан нь 2024-2028 онд хэрэгжүүлэх “Шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагжуулах сургалтын модуль”-ийн сургалтад 2025.03.24-2025.04.03-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газарт сургалтанд хамрагдсан байна. Мөн хуулийн этгээдийн бүртгэгч болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрхтэй сумдын бүртгэгч нар бүртгэлийн үйл ажиллагааг явуулж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2025.11.10-ний өдрийн байдлаар нийт 578 бүртгэл хөтлөгдсөнөөс шинээр 237 бүртгэл байна. Үүнд:

- ✓ ХХК -45
- ✓ Хоршоо -171
- ✓ Холбоо -18
- ✓ Үйлдвэрчний эвлэлийн хороо-3
- ✓ Мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл – 327
- ✓ Дахин гэрчилгээ – 43
- ✓ Хураалгасан тамга, тэмдэг – 63
- ✓ Тамга тэмдэгийн хяналтын хуудас-40
- ✓ Татан буугдсан-10

Үйлчилгээний орлого, тэмдэгтийн хураамжаар 19.732.000 төгрөгийн орлогийг төвлөрүүлсэн байна.

1.5. Санхүүгийн чиглэлээр:

2025 оны 10 сарын байдлаар улсын төсвөөс үйл ажиллагааны санхүүжилтэнд 1129312900 төгрөг авч, сар бүрийн төсвийн хуваарийн дагуу төсвийн урсгал зардалд 1071493404 төгрөг зарцуулаж, төсвийг зүй зохистой зарцуулан төсвийн хэтрэлт болон өр авлага үүсгэхгүй байхад анхааран ажиллаж байна. Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогоор орсон 99670813 төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс төвийн төрийн захиргааны 9 албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 42884350 төгрөгийн санхүүжилт авч 42284350 төгрөгийг олгосон.

Төсвийн зарлагыг төсвийн зүйл анги, зардлын төрлөөр харуулбал:

№	Зардлын нэр төрөл	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	
				Тоо хэмжээ	хувь



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	942574800	907515168,5	35059631,55	3,7
2	Нийгмийн даатгалын шимтгэл	128884100	107109815,3	21774284,69	83,1
3	Байр ашиглалтын зардал	32300900	31438530	862370	30,6
	Гэрэл цахилгаан	3150000	2800000	350000	11,1
	Түлш халаалт	27800000	27800000		
	Цэвэр, бохир ус	1350900	838530	512370	37,9
4	Хангамж. Бараа материалын зардал	17995400	17952391	43009	29,6
	Бичиг хэрэг	12964900	12962800	2100	0,01
	Тээвэр шатахуун	2113400	2113400		
	Шуудан холбоо	1995900	1967091	28809	1,4
	Хог хаягдал	60100	48000	12100	20,1
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	861100	861100		
5	Эд хогшил, урсгал засварын зардал	310100	310000	100	99,9
	Багаж, техник хэрэгсэл	150000	150000	0	
	Хөдөлмөр хамгааллын зардал	144100	144000	100	99,9
	Урсгал засвар	16000	16000		
6	Томилолт				
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	847600	847500	100	98,1
	Бусад нийтлэг АҮТХ	197500	197500	0	
	Тээврийн хэрэгслийн татвар	0			
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650100	650000	100	
8	Хичээл үйлдвэрлэлийн зардал	400000	320000	80000	
10	Нэг удаагийн тэтгэмж	100000	100000	0	0
	Дүн	11029312900	1071493404,76	57819495,24	5,1

Төсвийн гүйцэтгэлээс харахад 10 сарын байдлаар хэтрүүлж зарцуулсан зардал байхгүй, түлш халаалтын зардал дээр 6 сая төгрөгийн өр төлбөр үүссэнийг зардал хооронд зохицуулалт хийлгэх хүсэлтийг ерөнхий газарт хүргүүлсэн.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төсвийн гүйцэтгэл, мөнгөн хөрөнгө, өр авлага, үйлчилгээний орлогын мэдээг сар бүрийн 2-ны өдрийн дотор УБЕГ-ын санхүүгийн хэлтэст болон төрийн санд гаргаж өгч, шилэн дансанд 137 төрлийн мэдээ мэдээллийг бүрэн байршуулсан.

2025 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлан мэдээг хугацаанд нь гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүгийн тайланд нэгтгүүлсэн. Үнэт цаасны тайланг сар бүрийн 05-ны өдөр хүргүүлж, үйлчилгээний орлогыг сар бүрийн эцэст улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

1.6. Архивын үйл ажиллагааны чиглэлээр:

Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивт 2025 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн 734242, ЭХЭУБ-ийн 20932, ХЭУБ-ийн 2559 хувийн хэрэг хадгалагдаж байна.


Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Нийт 73686 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас хүүхдийн санд-13505 хүүхдийн хувийн хэрэг, хувийн хэрэгжсэн санд-40254 нас баралтын санд-18112 хувийн хэрэг, тодорхой бус иргэдийн санд-499, он тодорхой бус нас баралтын санд 1316-г он дараалал болон цагаан толгойн галигийн дарааллын дагуу архивт байршуулсан байгаа болно.

Иргэний баримт бичгийн архивт иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 8 төрөл, иргэний шинэчилсэн бүртгэлийн маягт-31 зэрэг төрлүүдээр нийт 1808 иргэдийн хувийн хэргийг жилийн эцсийн байдлаар хүлээн авч архивт байршууллаа. Төрөл тус бүрээр нь авч үзвэл ИУБ-11 маягт 334, ИУБ-12 маягт 14, ИУБ-13 маягт 15, ИУБ-14 маягт 13, ИУБ-15 маягт 101, ИУБ-16 маягт 24 г, ИУБ-18 маягт 179, ИУБ-31 маяг 1128 -г жагсаалтаар хүлээн авч архивт байршуулан ажиллаа. Мөн 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авах 630 хүүхдүүдийн хувийн хэргүүдийг хүүхдийн сангаас ялган салгаж тусад нь байршуулсан.

Орон нутгийн улсын бүртгэгч нараас оны эхэнд өмнөх оны бүртгэлийн бүрдүүлбэр материалууд болон иргэний 8 төрлийн бүртгэлийн журналуудыг жагсаалтаар хүлээн авч Улсын ахлах бүртгэгчээр хянуулан архивт хүлээн авч байршуулах ажил тогтмол хийгдэн явагдаж байна.

2024 онд хадгалах хугацаа дууссан 12406 хуудас бүхий 73 хадгаламжийн нэгж, 922 хуудас бүхий 20ш бүртгэлийн дэвтэр, 523ш ИУБ маягтуудын жагсаалтыг гарган устгалд оруулах саналыг 2024 оны 11 сарын 31-нд жагсаалтаар хүргүүлж устгах зөвшөөрөл ирсэний дагуу хэлтсийн даргын 2024 оны А/05 тоот тушаалаар комисс томилогдож устгах ажиллагааг 2025.01.20-ны өдөр явуулж, тайланг УБЕГ-т хүргүүлж ажиллалаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Иргэний 8 төрлийн бүртгэлээр болон ААН байгууллагад лавлагаа олгоход шаардлагатай архивын эх нотлох баримт болон журналыг лавлагаа хариуцсан улсын бүртгэгчид, ямар нэгэн зөрчилтэй ХУБ-дээр шалгагдах шаардлагатай иргэдийн хувийн хэрэг болон бусад шаардлагатай материалуудыг тухай бүрт нь гарган өгч ажиллалаа.

ЭХЭБ-ийн архивын чиглэлээр:

ЭХЭУБ-ийн архивт нийт 20601 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газраас бусад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 9366, газрын бүртгэл 11235, хадгалагдаж байгааг сум тус бүрээр газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээр ангилан архивт байршуулсан.



Архивт модон тавиур дээр байрлуулж байсан ЭХЭУБ-ын хувийн хэргүүдийн тавиурыг нягтруулсан шүүгээгээр сольж зөөн байршуулсан болно.

Энэ оны хагас жилийн байдлаар ЭХЭУБ-ийн архивт газраас бусад эд хөрөнгийн хувийн хэрэг 166, газрын хувийн хэрэг 296 шинээр бүртгэгдсэнг архивт журналаар хүлээн авч хавтаслан сум тус бүрээр шинээр хувийн хэрэг үүсгэн дугаарын дагуу байршуулж, нэмэлт үйлчилгээ хийгдсэн материалуудыг тухай бүрт нь мөн журналаар хүлээн авч архивын баяжилтанд байршуулан ажиллаа.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын чиглэлээр:

Тус тасгийн архивт 2024 оны жилийн эцсийн байдлаар 2298 аж ахуйн нэгжийн хувийн хэрэг байршиж байснаас шинээр 199, шилжин явсан 3, шилжин ирсэн 4, татан буугдсан 7 бүртгэл хийгдэж 2025 оны жилийн эцсийн байдлаар 2494 аж ахуйн нэгжийн хувийн хэрэг байршиж байна.

Цахимжилтанд ороогүй байсан 200 гаран хувийн хэргийг архиваас татан авч жагсаалтаар тасгийн ахлах улсын бүртгэгчид хүлээлгэн өгч цахимжуулан буцаан архивт жагсаалтын дагуу хүлээн авч байршуулах, мөн баяжилтанд ороогүй байсан 126 аж ахуйн нэгжийн нэмэлт материалыг архивт баяжилтанд оруулж ажиллаа. Аймгийн сум дундын шүүхээс маргаантай хуулийн этгээдийн хувийн хэргүүдэд үзлэг, шалгалт хийх үед холбогдох материалыг гарган өгч шаардлагатайг нь канондаж “ХУУЛБАР ҮНЭН” тэмдгээр баталгаажуулан хууль журмын дагуу гаргаж өгч ажиллаж байна.

Архивчийн өрөөний ханыг бүтэн имульдэн, шалны хулдаасыг шинээр солих мөн архивын байрны галын буланг сэргээн “Гамшиг ослын үед архивын байрнаас баримт материалыг зөөвөрлөх хуваарийг хэлтсийн даргын тушаалаар томилуулан, хэлтсийн байранд гамшиг осол гарсан үед хийх дадлага сургуулийг нэг удаа зохион байгуулан галын буланд дутуу байсан хүрз-2ш, галын цохиур, тармуур зэргийг шинээр нэмж байрлуулаа. Мөн архивын өрөөний цоорсон трубаг мэргэжлийн байгууллагаар солиулан шугам сүлжээний засварын ажлыг хийлгэсэн байна.

1.7. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Булган аймгийн УБХ-ийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ, интернэт сүлжээ, бүх албан хаагч,



сумдын улсын бүртгэгч нарын компьютер, принтер, хувилах төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд байнгын бэлэн байдлыг ханган тухай бүрт нь засвар үйлчилгээ хийгдэж, шинээр солих шаардлагатай бол шинэчилж ажиллаж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн болон сумдын хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид нийт 15 удаа засвар үйлчилгээг хийсэн. Ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, сайжруулалтын ажлыг байнга хийдэг бөгөөд “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл”-ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг.

БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 16 сум 1 тосгоны улсын бүртгэгч нарт компьютер 17 ширхэг, 3 үйлдэлт принтер 17 ширхэг, хурууны хээ уншигч 17 ширхэг, зургийн аппарат 17 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд тус бүрийн тоног төхөрөмжийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган программ хангамж зэргийг бүрэн суулган ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГазраас зохион байгуулсан мэдээ мэдээлэл, санхүү хүний нөөц, сар бүрийн тоон мэдээлэл, өргөдөл гомдлын мэдээлэл, имфографик мэдээлэл, видео мэдээ зэргийг цаг тухай бүрт нь www.bulgan.burtgel.gov.mn www.gov.mn www.emongolia.mn www.shilen.gov.mn гэсэн цахим хуудаснаа нийтлэн иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



БУЛГАН АЙМГИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Ардын сайд нарын Зөвлөлийн 1937 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийг Булган, Сэлэнгэ хоёр аймаг

Тайлант хугацаанд Булган аймгийн 16 сум, 1 тосгон, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагаа бүрэн хэвийн ажиллаж байгаа бөгөөд доорх засвар үйлчилгээг хийж ажилласан.

Үүнд:

- Хуулийн этгээдийн бүртгэгч шинээр орсонтой холбогдуулан программ хангамж тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагааг хангасан
- Хэлтсийн роутер /тог тасарсан/ эвдэрсэнг сольж хэлтсийн сүлжээний хэвийн байдлыг хангасан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- Бичиг хэрэг, хуулийн этгээдийн бүртгэгч гарт DR-70000 сканнерийг суулган программ дээр хэвийн ажиллагааг ханган ажлын бүтээмжийг дээшлүүлсэн
- Баяннуур сумын бүртгэгч Рашаант суманд ажиллахад сүлжээ орохгүй байсанг цаг алдалгүй гэмтлийг олж хэвийн ажиллагааг хангасан.
- Хэлтсийн сүлжээ тасараад конвертер гацсан байсанг олж ресет хийж хэвийн болгосон.
- Хуулийн этгээдийн бүртгэгчийн тоног төхөөрөмж /компьютер/ шичлэгдэж ирсэнг программ, дагалдах хэрэгсэлүүдийг таниулж хүлээлгэн өгсөн.
- Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн принтер гэрчилгээ дээр хар зураастай байсанг 3н үйлдэлт принтерээр шинээр сольж программ дээр таниулж өгсөн нь ажлын бүтээмжийг дээшлүүлсэн.
- Сумдын бүртгэгч нарын гэрчилгээ, үнэт цаас хэвлэх тохиргоо болон тоон гарын үсэг олголтын алдаа, сканер, принтер программын алдааг цахим болон утсаар тухай бүрд нь холбогдон алдааг засаж хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна.
- Бүрэгхангай болон Баян-агт сумын сүлжээ тасалдаж ажилгаагүй болсонг засаж хэвийн болгосон
- Starlink төхөөрөмжөөр Булган сумын нүүлгэн шилжүүлэлт болон хорих 469-р ангид 14 хүний бүртгэл хийсэн.
- Бугат сумын конвертер шатсанг шинэ конвертер иртэл хэлтэст ашиглагдаж байсан 4ж төхөөрөмжийг явуулан иргэдэд чирэгдэл учруулахгүй сүлжээтэй холбосон.
- Тэшиг сумын бүртгэгчийн компьютер сторез дүүрч программ ашиглах боломжгүй болсонг форматлан ашиглагддаг бүх хэрэглээний программ болон драйверүүдийг суулган хэвийн болгосон.
- Хэлтсийн сүлжээний шилэн кабель серверийг зөөн байрлуулж, шинээр сүлжээ татлаа.
- 8-н сум Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн эрх авсантай холбогдуулан Сэлэнгэ сумын программ ажилгааг хэвийн болголоо.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХОЁР. СУРГАЛТ, СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛСАН БОЛОН ХАМРАГДСАН БАЙДЛЫН ТАЛААР:

Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд Булган аймгаас зохион байгуулагдсан 10 удаагийн сургалтанд 32 албан хаагч, дотооддоо зохион байгуулсан 3 удаагийн танхим, 12 удаагийн цахим сургалтад нийт 24 албан хаагч, хамрагдаж бусад байгууллагын мэргэжилтэн албан хаагчдыг урьж 7 удаагийн сургалт мэдээллийг хүргүүлж байна.

- ✓ **Гадаад сургалтын хүрээнд:** Тайлант хугацаанд Удирдлагын академийн богино хугацааны зорилтод сургалтад Булган аймгийн Тэшиг, Сайхан, Бүрэгхангай, Могод, Сэлэнгэ сумын улсын бүртгэгч нар хамрагдан үнэмлэх авч өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлж ажиллалаа.



- ✓ **Дотоод сургалтын хүрээнд:** Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025.03.30-31-ны хооронд зохион байгуулсан удирдах ажилтныг мэргэшүүлэх сургалтад хэлтсийн дарга хамрагдсан. Мөн мэдээлэл технологийн ажилтнуудад зохион байгуулсан танхимын сургалтад мэдээлэл технологийн ажилтан Ө.Өлзиймөрөн, 2025.05.12-13-ны өдөр ИУБГ-аас зохион байгуулсан сургалтад улсын ахлах бүртгэгч Х.Нямсүрэн, улсын бүртгэгч Н.Бүрэндүүрэн нар хамрагдсан. Шинээр томилогдсон хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ц.Хуланг УБЕГ-т биечлэн “Шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах” сургалтад хамруулсан. УБЕГ-ын чиглэлийн газруудаас зохион байгуулж буй цахим сургалтуудад албан хаагчдыг тухай бүр бүрэн хамруулж ажиллалаа.



Мөн 2025.11.05-11.07-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Санхүүгийн албан хаагчдын чадавхжуулах сургалтад Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч В.Оюун-Эрдэнэ, Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав З. Энхзул нар оролцлоо.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



- ✓ **Дотоод сургалт-Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан сургалтаар:** Албан хаагчдыг ажлын байран дээр нь сургах зорилгоор анхан шатанд ажиллаж байгаа улсын бүртгэгч нарт 12 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж ажиллалаа.



Хэлтсийн дарга Ж.Ганболд 2025.01.23-ны өдөр Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад цахимаар болон танхимаар сургалтыг зохион байгуулж мэдүүлгийн цахим системийн ашиглалт болон ХАСХОМ гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг мэдэгдэх, тайлбарлахад анхаарах асуудлын талаар мэдээллийг хүргэсэн.



Хяналтын улсын байцаагч Э.Нандинцэцэг нь “**Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудлууд**” сэдвээр албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан.

- ✓ **Албан хаагчдад чиглэсэн бусад сургалтын хүрээнд:** Насан туршийн суралцахуйн төв, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль, эрх зүйн хэлтэс, Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газруудаас сургалт хүсч 7 удаагийн сургалтад албан хаагчдыг хамруулсан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2025.02.05-ны өдөр хэлтсийн албан хаагчдын ёс зүй, багаар ажиллах чадварыг дээшлүүлэхэд анхаарч ХЭҮК-ын ажилтан референт Д.Мөнхсайхан, Булган аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Оюунгэрэл нарыг урьж **“Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”** сургалтыг зохион байгуулсан.



Хүүхдийг #Зодож#Шийтгэхгүй байх олон улсын өдрийг тохиолдуулан "Зөвөөр үлгэрлэе" арга хэмжээг зохион байгуулж аймгийн ХГБХХГазрын мэргэжилтэнг урьж албан хаагчдад **"Хүүхэд хамгаалал"**-ын талаар мэдээллийг хүргэсэн.



2025.03.10-ны өдөр Булган аймгийн Насан туршийн боловсролын төвийн мэргэжилтэнг урьж хэлтсийн албан хаагчдад **“Хувь хүний хөгжил EQ тодорхойлох”** сургалтыг зохион байгуулж хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулсан.



2025.06.30-ны өдөр хүүхдийг #Зодож#Шийтгэхгүй байх олон улсын өдрийг тохиолдуулан "Зөвөөр үлгэрлэе" арга хэмжээг зохион байгуулж аймгийн ХГБХХГазрын мэргэжилтэнг урьж албан хаагчдад **"Хүүхэд хамгаалал"**-ын талаар мэдээллийг хүргэсэн.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр "БҮРТГЭЛИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН СУРГАЛТ"-ыг зохион байгуулж ажиллаа. Энэхүү сургалтын онцлог нь:

- ✓ Албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх
- ✓ Улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр хангах
- ✓ Улсын бүртгэл эрхлэн хөтлөхөд анхаарах асуудлууд
- ✓ Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын тухай ойлголт
- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны талаар
- ✓ Цаашид авч хэрэгжүүлэх ажил үйлчилгээний чиглэлээр зохион байгуулагдлаа.

- 👉 **#НЭГДСЭН СУРГАЛТ**-д урилгаар Булган аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Г.Цэрэнчимэд хүрэлцэн ирж Авлигын тухай ойлголт, холбогдох зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээллийг хүргэж хамтран ажиллалаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Булган аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Оюунгэрэлийг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-иар сургалт зохион байгуулж ёс зүйн зөрчил гаргахаас сэргийлж төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэгийг нэмэгдүүллээ.



2025.10.28-нд Булган аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш Г.Сарантуяаг урьж “Харилцаа хандлага ба тогтвортой байдалд суралцахуй” сэдвээр сургалт зохион байгуулж албан хаагчид харилцааг амжилттай болгох гол хүчин зүйл бол эерэг хандлага юмаа гэдгийг ойлгосон үр дүнтэй сургалт болсон.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГУРАВ. АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

✓ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар, салбарын хөдөө орон нутагт ажиллаж буй алба хаагчид болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрт илрүүлэг хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээний 2 дугаар ээлжийн үзлэг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 19-ны өдрүүдэд Булган аймагт зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээнд Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 11, сумын 5 албан хаагч, нийт 16 албан хаагч тэдний гэр бүлийн 14 гишүүн үзлэг оношилгоонд хамрагдсан байна.



✓ 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хэлтсийн албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийтэч сэтгэлгээ хамт олонч үзэл сурталыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд Булган аймгийн Музейтэй хамтран албан хаагчдыг ажлын байрнаас нь Вертуал музейгээр аялууллаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- ✓ Булган аймгийн Рашаант сумын улсын бүртгэгч А.Раднаабаяр, Хангал сумын улсын бүртгэгч Д.Гантулга нараас гэр бүлээ дагаж өөр суманд шилжин ажиллах тухай хүсэлт ирүүлсэнийг шийдвэрлэж А.Раднаабаярыг Хангал суманд, Д.Гантулгыг Могод суманд шилжүүлэн ажиллуулсан.
- ✓ Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гэрбүлд нь шинэ хүүхэд төрсөн 1 албан хаагчид 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон.
- ✓ 2025.05.31-ний өдөр нотариатчдын тэнхимээс хууль хүчний байгууллагуудын дунд зохион байгуулсан “3-н төрөлт спортын тэмцээн”-д байгууллагын албан хаагчид авхаалж самбаа, хурд хүчээ сорин амжилттай оролцсон.



Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойг угтан Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид байгууллагын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах ажлыг өрнүүлж тасалгааны цэцгүүдийг шинэчилж, савлагааг сольж байршуулан Байгууллагын ажилтан, албан хаагчдын идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, эко соёлыг төлөвшүүлэх чиглэлийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Цаг-Гаргая" уриатай "ЯВГАН АЛХАЛТ"-ыг [#Эв нэгдлийн их цагаан суварга](#) хүртэлх зайд зохион байгуулж, Эв нэгдлийн музейг үзэж сонирхон нэгэн өдрийг адал явдлаар дүүрэн, үр бүтээлтэй өнгөрүүллээ.



Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор дасгал хөдөлгөөн, идэвхтэй амьдралын хэв маягт уриалан дасгал хөдөлгөөн хийж, хөгжилтэй буухиа зохион байгуулж нэгэн оройг үр бүтээлтэй өнгөрүүллээ. Хөдөлгөөн нь хүний сэтгэл зүйд эерэгээр нөлөөлж, сэтгэх, анхаарлаа төвлөрүүлэх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан “ӨГЛӨӨ БҮР БИЕ БИЕДЭЭ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ, ХАМТ ОЛОНДОО ЭЕРЭГ ӨДРИЙГ БЭЛЭГЛЭЭ” уриатай “Гэгээн өглөө” арга хэмжээг зохион байгуулан өглөөний цайг хамт олноороо ууж, бие биедээ талархал илэрхийлэн нэгэн өглөөг инээд хөөр, эрч хүчээр дүүрэн эхлүүлж хамт олны дунд эерэг уур амьсгалыг нэмэгдүүлж, албан хаагчдыг урам зоригыг нэмэгдүүллээ



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Албан хаагчдыг дэмжих, байгууллагын дотоод соёлд ёс зүйн үнэт зүйлийг төлөвшүүлэх, ажлын орчинд харилцан хүндлэл, шударга ёсыг дэмждэг албан хаагчдыг нийтэд таниулах зорилгоор байгууллагынхаа хамт олны дунд үлгэр жишээ болсон бусдыгаа үргэлж дэмждэг, харилцаа хандлага сайтай албан хаагчдыг хамт олны саналаар шалгаруулж байгууллагын “ЁС ЗҮЙТЭЙ АЛБАН ХААГЧ”-аар өргөмжилж хэлтсийн пэйсбүүк, пэйж хуудсанд алдаршуулж, урамшууллаа

Булган Улсын Бүртгэлийн Хэлтэс
24 October at 12:12 · 🌐

📢 Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 16 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтан зохион байгуулж буй төлөвлөгөөт ажлын хүрээнд, Байгууллагын #ШИЛДЭГ_ЁС_ЗҮЙТЭЙ_АЛБАН_ХААГЧ-дыг шалгарууллаа. 🏆 👤
Хариуцла... See more

БУЛГАН АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

**ШИЛДЭГ ЁС ЗҮЙТЭЙ
АЛБАН ХААГЧ**

Байгууллагынхаа үнэт зүйлсийг
эрхэмлэн, шударга ёс, харууцлага,
харилцан хүндлэлээр хамт
олондоо үлгэр дуурайлал болсон
Танд баяр хүргэе.

Хяналтын үндсэн байцаагч
Э.Нандицэцэг

Энгийн амжилт
Хүндэтгэлийн хэлтэс

ШИЛДЭГ ЁС ЗҮЙТЭЙ
АЛБАН ХААГЧ

Түүнийг хамгаалж, үнэт зүйлсийг
эрхэмлэн, шударга ёс, харууцлага,
харилцан хүндлэлээр хамт
олондоо үлгэр дуурайлал болсон
Танд баяр хүргэе.

Энгийн амжилт
Хүндэтгэлийн хэлтэс

ШИЛДЭГ ЁС ЗҮЙТЭЙ
АЛБАН ХААГЧ

Түүнийг хамгаалж, үнэт зүйлсийг
эрхэмлэн, шударга ёс, харууцлага,
харилцан хүндлэлээр хамт
олондоо үлгэр дуурайлал болсон
Танд баяр хүргэе.

Энгийн амжилт
Хүндэтгэлийн хэлтэс

See insights and ads

Boost post

3, Энхзул, Batnasan Pownoo and 109 others

40 comments 18 shares

ТАЛАРХАЛ

Улсын бүртгэлийн хэлтсийн 85 хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Н.Болтгүй,
Б.Олончимэг, Хуулийн этгээлийн улсын бүртгэгч Ш.Хуучин нарт

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан,
төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэн албан хаагчдад ортгойн зүтгэх
талархал өргүүрсн байна.

ТА БҮХЭНД АЖЛЫН ӨНДӨР АМЖИЛТ ХҮСЬЕ
2023.06.20.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Байгууллагын дотоод соёлд ёс зүйн үнэт зүйлийг төлөвшүүлэх, ажлын орчин дахь харилцан хүндлэлийг бий болгож, хамт олны дунд эерэг уур амьсгалыг нэмэгдүүлэх, албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг дэмжих зорилгоор нөлөөллийн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн 2025.09.12-ны өдөр “ХӨГЖИЛТЭЙ ХӨЛС” уриатай байгууллагын “Гар бөмбөгийн аварга” шалгаруулах спортын нөхөрсөг тэмцээнийг өвөрмөц байдлаар зохион байгуулж нэгэн өдрийг хөгжилтэй, эрч хүчтэй, спортлог өнгөрүүлэн байгууллагын аваргуудаа алдаршууллаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ДӨРӨВ. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР:

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах, Төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох ажлын хүрээнд Сайхан, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Сэлэнгэ сумын улсын бүртгэгчид Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээний тоон үзүүлэлтийн талаарх мэдээллийг сум орон нутгийнхаа ажилтан, албан хаагчдад танилцуулах сургалтыг зохион байгуулж ажиллалаа.



2025.03.14-ны өдөр Хяналтын улсын байцаагч, Улсын ахлах бүртгэгч нар “Булган мээж” ХХК-ны ажилтан, албан хаагчдад улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг хүргэж тоон гарын үсэг олгож ажилласан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Бүртгэл-85” аяны хүрээнд 2025.05.30-ны өдөр зөөврийн төхөөрөмж ашиглан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-439 дүгээр хаалттай хорих ангид очиж Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж ажилласан.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн хүрээнд Булган аймгийн Хялганат тосгонд “ЗӨВЛӨӨ-БҮРТГЭЭ” арга хэмжээг зохион байгуулж 60 гаруй иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээллийг хүргэн, зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэн газар дээр нь шийдвэрлэж, улсын бүртгэлийн үйлчилгээг “ГАРААС-ГАРТ” шуурхай олгон бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн хүрээнд Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2025.06.24-ний өдөр Булган аймгийн Хутаг-Өндөр суманд "ЗӨВЛӨӨ-БҮРТГЭЭ" арга хэмжээг зохион байгуулж 80 гаруй иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээллийг хүргэж, зөрчлийн тухай хууль хэрэгжүүлэн газар дээр нь шийдвэрлэж, улсын бүртгэлийн гэрчилгээг "ГАРААС-ГАРТ" шуурхай олгон, 69 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.



Мөн олон нийтэд бүртгэлийн үйл ажиллагааг танилцуулах арга хэмжээ үе шаттайгаар зохион байгуулж ажиллаа. Уг ажлын зорилго нь:

- Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах
- Төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох ажлын хүрээнд

Орхон сумын улсын бүртгэгч Сувд-Эрдэнэ Дугарсүрэн тус сумын Халиун багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулга, мэдээллийг хүргэж ажиллалаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах зорилгоор "ЗӨВЛӨӨ-БҮРТГЭЭ" арга хэмжээг 2025.10.05-06-ны өдрүүдэд Гурванбулаг суманд зохион байгуулж Улаабаатар хотын Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч М.Лхагвасүрэнтэй хамтран 70 гаруй иргэнд мэдээлэл хүргэж, бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.



"ЗӨВЛӨӨ, БҮРТГЭЭ" арга хэмжээг 2025.10.17-ны өдөр Орхон суманд зохион байгуулж 20 гаруй хуулийн этгээдэд "Эцсийн өмчлөгч"-ийн талаар мэдээлэл хүргэж, 5 хуулийн этгээдийг "Эцсийн өмчлөгч"-өөр бүртгэж, гэрчилгээг олголоо.



Тайлант хугацаанд авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн өмнө оны болон 1 контентыг болон УБЕГ-аас бэлтгэсэн контентийг иргэд олон нийтэд цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилж ажилласан бөгөөд үйлчилгээний танхимд мэдээллийн самбарыг байршуулж, энэ оны IV дүгээр улиралд багтаан шинээр 1 контент бэлтгэн түгээхээр төлөвлөн ажиллаж байна.




БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан “Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэх түгээх” арга хэмжээний хүрээнд Булган аймгийн “Сайхан Монгол” телевизтэй хамтран Төрөлтийн бүртгэлийн талаар контент бэлтгэн хэлтсийн пэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд түгээж ажиллалаа.



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр буюу 8 улирал дараалан санхүүгийн тайлан илгээгүй хуулийн этгээдийн талаар цахим видео контент бэлтгэн хэлтсийн пэйсбүүк, пэйж хуудсанд байршуулж иргэн, хуулийн этгээдэд сурталчилан ажиллаж байна.




БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Мөн үйл ажиллагаатай холбогдуулсан гаргасан авлигын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай, авлигын эсрэг шүгэл үлээх, авлигын талаар мэдээлэл зэрэг түүнтэй холбогдуулан гаргасан тараах материал болон авлигын хор хөнөөлийг таниулж суртчилсан соён гэгээрүүлэх контент хийж хэлтсийн фэйсбүүк цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.



Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэний үнэмлэх шинээр авах, сольж олгох тохиолдолд хуульд заасан хугацаанд бүртгүүлэх талаар мэдээлэл бэлтгэн хэлтсийн үйлчилгээний танхим, пэйсбүүк, пэйж хуудсанд байршуулсан. Мөн гэрлэлтийн бүртгэл бүртгүүлэхэд бүрдүүлэх материал, гэрлэлтийн гэрээний тухай гарын авлага бэлтгэн үйлчилгээний танхимд байршуулан гэрлэлт бүртгүүлж буй иргэдэд танилцуулан мэдээлэл хүргэн ажиллаж байна.



Зөрчлөөс урьдчилан сэргийлж зөрчлийн талаарх ойлголт мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд хүргэх зорилгоор гарын авлага, зурагт хуудас бэлтгэн хэлтсийн пэйсбүүк, пэйж хуудсанд байршуулан ажиллалаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд түүхэн фото зураг болон архивын эх нотлох баримтаар үзэсгэлэн гаргалаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд эцэг эхийн зөвлөлөөс “Улсын бүртгэл-85” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулж #Шилдэг_6 бүтээлийг шалгарууллаа.




БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж, шуурхай хүргэх зорилтын хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын зөөврийн төхөөрөмжийг ашиглан ШШГЕГ-ын харьяа Хорих 439 дүгээр хаалттай хорих ангитай хамтран "ЗӨВЛӨЕ БҮРТГЭЭ" арга хэмжээг зохион байгуулж 13 иргэнд иргэний үнэмлэхийн бүртгэл, 12 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.



Байгууллагын архивийн гал түймэр унтраах шийдвэрлэх чиглэлийг зөв тодорхойлон шаардагдах хүн хүч, хэрэгслийг тооцоолж гал түймэр унтраах, нэмэгдэл хүн хүч, хэрэгслийг нэгэн зэрэг дуудаж угтах ажлыг зохион байгуулах чиглэлээр дадлага сургалтыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран амжилттай зохион байгууллаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ТАВ. “ТЭР БУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон Улсын бүртгэлийн байгууллага үүсэж, хөгжсөний 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус хэлтсийн албан хаагчид хаврын мод тарилтыг 2025.05.09-ний өдөр зохион байгуулан 70 ширхэг мод, намрын мод тарилтыг 2025.10.10-ны өдөр зохион байгуулж 26 ширхэг мод шинээр тарьж “Улсын бүртгэлийн төгөл” байгуулан усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэсэн. 2025 онд нийт 96 мод шинээр тарьсан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




ЗУРГАА. “МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД:

2025 оны эхний улиралд Булган аймгийн Ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Д.Гүнсмаагаар анхан шатны 20 цагийн хичээлийг заалган албан хаагчыг бүрэн хамруулж анхан шатны мэдлэгийг давтан эзэмшүүллээ.

Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын дагуу албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх ажлын хүрээнд 2025.02.20-ны өдрөөс эхлэн албан бичиг болон хэлтсийн даргын тушаалыг хос бичгээр хөтөлж эхэлсэн. Эхний хагас жилийн байдлаар 52 албан бичиг, 12 тушаалыг хос бичгээр 100% хөтлөөд байна.

2025.05.09-ны өдөр Насан туршийн суралцахуйн төвийн мэргэжилтэн багшийг урьж “Цахим-бичвэр”-ийн сургалтыг зохион байгуулж хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулсан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Албан хаагчдыг монгол бичгийн чадвар эзэмшүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор нийт албан хаагчдыг монгол бичгийн хичээлд бие даан суралцуулж. Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформ (<https://surgalt.gov.mn/>)- д байршуулсан монгол бичгийн дунд шатны хичээлд хамрууллаа. Уг хичээлд хамрагдсан албан хаагчдаас 25 албан хаагч анхан, дунд, ахисан шатны сертификатаа авсан.



ДОЛОО. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

"Үндэсний дээл хувцасаа өмсөж хэвших" уриалгын дагуу Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид өв соёлоо түгээн дэлгэрүүлэх **#ДЭЭЛТЭЙ ДАВАА ГАРАГ**-ийг зохион байгуулж хэвшүүлэн, Монгол үндэсний бахархал болсон үндэсний дээл хувцасаа өмсөн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Эхний хагас жилийн байдлаар "ЦЭВЭР
ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН" аяны
хүрээнд 2 удаа байгууллагын ойр
орчмын цэвэрлэгээ болон авто зам
дагуух хуваарьт цэвэрлэгээг хийж
гүйцэтгэлээ



2024.03.27-ны өдөр Гамшгийн
аюулын тухай зарлан мэдээллийн
дуут дохиогоор ажиллах нэгдсэн
дадлага сургуулилтад дүрмийн дагуу
УБХ-ын ажилтан албан хаагчид
бэлэн байдлыг ханган оролцсон



Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

